

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

20.19 оны 08 дугаар сарын
16.-ны өдөр

Дугаар 269/А/271

Улаанбаатар хот

Журам, сургалтын жишиг хөтөлбөр батлах тухай

Усан замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "сургалтын жишиг хөтөлбөр"-ийг хоёрдугаар хавсралтаар, усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолоочийн үнэмлэхний загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх, жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох арга хэмжээг Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехникийн коллеж бусад холбогдох эрх бүхий төрийн болон төрийн бус, мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, ажиллахыг Далайн захиргаа /С.Түвшинтөр/-нд үүрэг болгосугай.

3. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Батболд/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/-т тус тус үүрэг болгосугай.



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД



**“Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч
бэлтгэх журам, сургалтын жишиг хөтөлбөр”-ийн төсөлд хийсэн
нөлөөллийн шинжилгээ**

1. Журам батлуулах үндэслэл, шаардлага

Өнөөгийн байдлаар хөрш орнуудад ашиглагдаж байсан усан замын тээврийн хуучин хэрэгслийг бага, дунд боловсролтой мэргэжлийн бус иргэд жолоодон нийтэд үйлчилгээ үзүүлж байгаад онцгой анхаарч, тэдний усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын талаарх мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх шаардлага гарч байна.

“Усан замын тээврийн тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтад “усан замын тээврийн боловсон хүчин, тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална” гэж заасан ба мөн Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.10-т “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын агуулгыг тогтоох, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлах, дадлагын сургалтын үйл ажиллагааг зохицуулах баримт бичгийг батлах”, 8.4.11-д “мэргэжлийн ур чадварыг үнэлэх, шалгах, баталгаажуулах хөндлөнгийн шалгалт зохион байгуулах” зэрэг үүргийг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгасан.

Түүнчлэн Усан замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т усан замын тээврийн хэрэгслийг жижиг, бага, дунд, том оврын гэж ангилан, жижиг болон бага оврын усан замын тээврийн хэрэгслийг жолооч, мэргэшсэн жолооч жолоодох, харин дунд, том оврын усан замын тээврийн хэрэгслийг дипломын боловсрол эзэмшсэн иргэн /ахмад/ удирдахаар тус тус заасан.

Хуулийн эдгээр заалтыг хэрэгжүүлэх, усан замын тээврийн хэрэгслийн жолоочийг сургаж бэлтгэн дадлагажуулж, мэргэжлийн ур чадварыг нь дээшлүүлэх замаар усан замын тээврийн хэрэгслийн болон усан замын тээврийн үйлчилгээний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд “Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөр”-ийг шинээр боловсруулж батлуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Иймээс энэхүү журам, сургалтын жишиг хөтөлбөрийн төслийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулж, сургалт явуулах хуулийн этгээд нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14.4-т заасны дагуу бүртгүүлсэн, сургалтын орчин, шаардлагатай материаллаг баазыг бүрдүүлсэн, мэргэжлийн боловсон хүчинтэй байх шаардлагыг хангасан, хууль тогтоомжид нийцүүлэн чанартай сургалт явуулах, сонсогч, төгсөгчдийн талаарх мэдээллийн сантай байх, мэргэжлийн шалгалт авах зэрэг асуудлыг зохицуулахаар журамд тусгаад байна.

Сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг үнэлэх, шалгаж баталгаажуулах хөндлөнгийн шалгалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний асуудал эрхэлсэн байгууллага зохион байгуулахаар журмын төсөлд тусгав.



2. Журмын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү журмаар усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтыг Монгол Улсын нутаг дэвсгэрт зохион байгуулах, мэргэжлийн шалгалт авах, усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх олгох, хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд усан замын тээврийн хэрэгслээр ажил, үйлчилгээ эрхэлж буй болон эрхлэх иргэн, хуулийн этгээдэд хамаарна.

Журмын төсөл нь 6 хэсэг, 64 заалттай. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөрийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, тогтоомж болон усан замын тээврийн салбарт мөрдөгдөж буй хууль, тогтоомж, 2010 онд эмхэтгэн гаргасан “Бага оврын усан онгоц, завийг осол аюулгүй жолоодох” гарын авлага, 2018 онд батлагдсан “Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм”, “Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм”-тэй уялдуулан боловсруулав. Сургалтын жишиг хөтөлбөр болон жолоочийн үнэмлэхийн загварыг журмын хавсралтаар батална.

3. Журмын төсөл батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөж болохуйц бүлгийг тодорхойлох

Журмын төсөл батлагдсаны дараа Монгол Улсын гол, мөрөн, нууруудад усан замын тээврийн хэрэгслээр зорчигч болон ачаа тээврийн ажил, үйлчилгээ эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг, сонирхол нь ямар нэг байдлаар хөндөгдөхгүй.


4. Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авилга гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх

Журмын төсөл нь хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авилга гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулаагүй болно.

Төсөлд ялгаварлан гадуурхсан эсхүл аль нэг бүлэгт давуу байдал үүсгэсэн, жендерийн эрх тэгш байдлыг хөндсөн, дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөөлсөн, хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдөл бий болгосон заалтыг тусгаагүй болно.

Мөн аль нэг аж ахуйн нэгжид, ялангуяа зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэл бий болгох, төрийн байгууллага болон бусад иргэн, хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгох, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэсэн, хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлсөн зохицуулалтыг агуулаагүй болно.


5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа урьд нь батлагдсан шийдвэр байгаа эсэх, тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүү эдийн засгийн тогтолцоо.



Тухайн асуудлыг зохицуулсан ямар нэгэн шийдвэр өмнө нь байгаагүй ба шинэчлэн батлагдсан Усан замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9. дэх заалтад “усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх, сургалтын хөтөлбөр батлах журам”-ыг мэргэжлийн боловсрол, сургалтын болон усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар заасны дагуу журмын төслийг Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн шинээр боловсруулсан.

6. Журмын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо

“Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх, сургалтын хөтөлбөр батлах журам”-ыг Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, бүсийн сургалтын төвүүдийг түшиглэн хувийн хэвшлийн оролцоотойгоор хэрэгжүүлэхэд төрөөс санхүү, эдийн засгийн зардал гарахгүй болно. Харин сургагч багш нарыг бэлтгэхэд гарах бага хэмжээний зардлыг сургалтын төлбөрөөс санхүүжүүлэх боломжтой.



ТАНИЛЦУУЛГА

“Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөр”

Хаант Оросын худалдаачид Монгол Улсын хойд хязгаараас түүхий эд тээвэрлэх зорилгоор 1910 онд Хөвсгөл нуурт модон онгоц тавьж ажиллуулж эхэлснээр Монгол Улсын усан замын тээврийн салбар үүсч хөгжсөн гэж үздэг ч 1930-50-аад оныг хүртэл тухайн үеийн ЗХУ-ын /хуучин нэрээр/ Дорнод Сибирийн усан замын газрын Хөвсгөл нуур дахь салбар байв.

Энэ үед Зөвлөлтийн /хуучин нэрээр/ мэргэжилтнүүд Монгол ажилчдыг галч, усан цэрэг, залуурчин, механикч мэргэжлээр дагалдуулан сургаж байлаа.

Дорнод Сибирийн усан замын газрын Хөвсгөл нуур дахь энэхүү салбарыг усан онгоц, дагалдах бүх чиргүүл, зогсоолын байгууламж, бусад тоног төхөөрөмжийн хамт БНМАУ-ын талд 1952 онд буцалтгүй тусламжаар ЗХУ /хуучин нэрээр/ шилжүүлэн өгснөөр Монгол Улсын усан замын тээврийн салбар үүсч хөгжсөн бөгөөд Хөвсгөлийн усан замын газар шинээр байгуулагдаж, улмаар ЗХУ-д /хуучин нэрээр/ усан онгоцны удирдлага, инженер, мөн дунд мэргэжлээр 8 хүнийг суралцуулж эхэлснээр усан замын тээврийн салбарын үндэсний мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэж эхэлсэн түүхтэй.


Монгол Улс усан замаар 1952-1989 он хүртэл ЗХУ-тай хийж байсан худалдааны эргэлт 1990 оноос бүрэн зогссон, өмч хувьчлагдсан, хөдлөх бүрэлдэхүүн хуучирсан, мөн байгаль орчны асуудлаас усан замын тээврийн салбар 2000 оны дунд үе хүртэл зогсонги байдалд орсон.

Энэ үеэс Хөвсгөл нуурт хувийн завь бүхий нутгийн цөөн тооны иргэн аялал жуулчлалын зориулалтаар усан замын тээврийн үйл ажиллагаа эрхэлж байсан бөгөөд тухайн үед Хөвсгөл нуурт 10 хүрэхгүй усан замын тээврийн хэрэгсэл бүртгэгдэж байв.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2018 онд улсын хэмжээнд зохион байгуулсан усан замын тээврийн хэрэгслийн техникийн үзлэг, тооллогод 129 орчим усан замын тээврийн хэрэгсэл хамрагдсан бөгөөд цаашид тээврийн хэрэгслийн тоо өсөх хандлагатай байгаа ба тэр хэмжээгээр усан замын тээврийн хэрэгслийн осол гарах эрсдэл нэмэгдэж байгаа нь завь жолоодогчдыг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх шаардлага гарч байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан байгаль орчинд ээлтэй усан замын тээврийг хөгжүүлэхэд тус яамнаас анхаарч төрийн байгууллагууд, хувийн хэвшил, иргэд хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор салбарын гол хууль “Усан замын тээврийн тухай” хуулийг 2017 онд шинэчлэн батлуулсан.

Уг хуульд усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх, жолоочийн хариуцлагын даатгал, зорчигч, жолоочийн амь насны даатгалын асуудлыг тусгаж, усан замын тээврийн хэрэгслийн ангиллыг тогтоож, их, дээд сургууль төгссөн болон зохих сургалтад хамрагдаж үнэмлэх авсан этгээд нь тохирох ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох эрхтэй байх тухай заалтуудыг тус тус шинээр тусгасан болно.



“Усан замын тээврийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9-т “Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөр”-ийг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлахаар тусгагдсан.

Иймд усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтыг зохион байгуулах, мэргэжлийн шалгалт авах, хяналт хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулах шаардлагын үүднээс журмын төсөл болон сургалтын хөтөлбөрийн төслийг шинээр боловсруулаад байна.

Усан замын тээврийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах, сургалтын хөтөлбөрийг боловсруулж батлах асуудлыг Усан замын тээврийн тухай шинэчилсэн хуульд тусгаж, тусгай журмаар зохицуулахаас өмнө усан замын тээврийн аюулгүй байдлыг хангах зорилгоор усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгчид болон завь жолоодогчдод хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, аюулгүйн ажиллагааны заавар, зөвлөмжөөр хангах зорилго бүхий сургалт, семинарыг Зам, тээврийн хөгжлийн яам, түүний харьяа Далайн захиргаа жил бүр Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд төрийн болон төрийн бус байгууллагуудын орон нутгийн салбаруудтай хамтран зохион байгуулж ирлээ.

Усан замын тээврийн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг дотооддоо сургаж, бэлтгэх, дадлагажуулах сургалтын материаллаг бааз байхгүй тул манай улс ОХУ, БНХАУ, БНСУ, Швед зэрэг далайн олон улсын худалдааны салбарын туршлагатай улс орнуудын их, дээд сургуулиудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд цөөн тооны иргэдийг хөлөг онгоцны инженер, удирдлагын мэргэжлээр бэлтгэж байна. Гэсэн хэдий ч шинээр батлагдсан хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус яам нь журмын зохих шаардлагуудыг хангасан сургалтын байгууллагуудыг түшиглэн тусгай сургалтын хөтөлбөрөөр усан замын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, мэргэшүүлэх сургалтыг явуулахаар төлөвлөж байна.

Шинэчилсэн хуулийн усан замын тээврийн хэрэгслийн ангилал тогтоосон 10 дугаар зүйлийн 10.4. дэх заалтад жижиг болон бага оврын усан замын тээврийн хэрэгслийг усан замын тээврийн хэрэгслийн жолооч, эсхүл мэргэшсэн жолооч жолоодох, харин дундаас дээш ангиллын усан замын тээврийн хэрэгслийг ахмад удирдах талаар тус тус заасан.

Энэхүү журмаар Монгол Улсын нутаг дэвсгэрт усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтыг зохион байгуулах, мэргэжлийн шалгалт авах, усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх олгох, хяналт тавихтай холбогдсон харилцааг тус тус зохицуулна.

Сургалтын жишиг хөтөлбөрийг усан замын тээврийн салбарт мөрдөгдөж буй хууль, тогтоомж болон 2010 онд эмхтгэн гаргасан АНУ-ын Хойд Дакота мужийн Эргийн хамгаалалтын албаны сургалтын гарын авлага “Бага оврын усан онгоц, завийг осол аюулгүй жолоодох” гарын авлагад тулгуурлан боловсруулсан бөгөөд уг сургалтын жишиг хөтөлбөр болон жолоочийн үнэмлэхийн загварыг энэхүү журмын хавсралтаар батална.

Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалт явуулахад зориулсан орчин, материаллаг баазыг бүрдүүлэх, мэргэжлийн багштай байх зэрэг шаардлагуудыг хангасан байгууллага (цаашид “сургалтын төв” гэх) нь хууль тогтоомжид нийцүүлэн сургалт явуулах, харин холбогдох төрийн байгууллага



нь сургалтын үйл ажиллагаа, чанарт хяналт тавих, мэргэжлийн шалгалт авах асуудлыг зохицуулсан заалтууд журмын төсөлд тусгагдсан.

“Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөр”-ийн төслөөр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгж болон завь жолоодогчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулан санал авсан ба тус яамны болон түүний харьяа Монгол Улсын Далайн захиргааны албан ёсны цахим хуудаст журмын төслийг байршуулж, олон нийтийн санал авах зэрэг ажлуудыг Захиргааны ерөнхий хуулийн шаардлагын дагуу зохион байгуулсан болно.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ



Зам, тээврийн хөгжлийн сайд,
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
хамтарсан 2019 оны 08 дугаар сарын 16-ны
өдрийн 10 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧ,
МЭРГЭШСЭН ЖОЛООЧ БЭЛТГЭХ
ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Монгол Улсын нутаг дэвсгэрт усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтыг зохион байгуулах, мэргэжлийн шалгалт авах, усан замын тээврийн хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэх (цаашид "жолоочийн үнэмлэх" гэх) олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан хуулийн этгээд усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн явуулна.

1.3. Усан замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан жижиг, бага оврын ангилалын усан замын тээврийн хэрэгслийг ахуйн зориулалтаар ашиглаж буй тохиолдолд усан замын тээврийн хэрэгслийн жолооч нь төлбөртэй үйлчилгээ зорчигчид үзүүлэхгүй бөгөөд ачаа, аюултай ачаа, овор ихтэй, урт хүнд ачаа тээвэрлэхээс бусад ажил, үйлчилгээ буюу зөвхөн амин хувийн хэрэгцээний ажил, үйлчилгээг гүйцэтгэнэ.

1.4. Зорчигчид усан замын тээврийн үйлчилгээг зохих төлбөртэй үзүүлж буй усан замын тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч нь Усан замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан /том оврынхоос бусад/ ангиллын усан замын тээврийн хэрэгслийг /5 тонноос ихгүй даацтай чиргүүл болон усан замын тээврийн хэрэгсэл чирэх/ жолоодож ажил, үйлчилгээг гүйцэтгэх ба түүний дотор аюултай, овор ихтэй, урт, хүнд ачаа тээвэрлэх ажил үйлчилгээ багтана.

1.5. Усан замын тээврийн хэрэгслээр аюултай ачаа тээвэрлэх асуудлыг Усан замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан "Усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам"-аар зохицуулна. /ЗТАЖС 2006.04.05 №45. Улсын бүртгэл 2006.09.27 №2637

1.6. Эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн, 18 насанд хүрсэн, "В" ангиллын авто тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхтэй, Монгол Улсын иргэн усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтад хамрагдаж болно.

1.7. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж зөрчсөний улмаас усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хугацаа нь дуусаагүй этгээдийг энэхүү сургалтад элсүүлэхгүй.

1.8. Сургалтын төв нь суралцагч болон сургалтыг явуулах багш нартай гэрээ байгуулна.

1.9. Усан замын тээврийн хэрэгслийн жолоочийг 3 сар, мэргэшсэн жолоочийг 1,5 хүртэл сарын хугацаагаар сургалтад хамруулна.

1.10. Энэ журмын 1.2-т заасан байгууллага болон Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон Усан замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10-т заасан байгууллагаас томилсон мэргэжлийн шалгалтын комисс энэ журмын дагуу сургалтын хөтөлбөрт бүрэн хамрагдсан суралцагчаас мэргэжлийн шалгалтыг авна.

1.11. Сургалтын төв нь төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг үнэлүүлэх, шалгуулах, баталгаажуулах хөндлөнгийн шалгалт зохион байгуулах хүсэлтээ мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний асуудал эрхэлсэн байгууллагад 30 хоногийн дотор хүргүүлнэ.

Хоёр. Сургалтын төвд тавигдах шаардлага

2.1. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалт явуулах сургалтын төв нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1. Сургалт явуулах анги танхим нь хичээлийн зориулалтай, суралцагчдад хүрэлцэхүйц тооны ширээ, сандал, зохих үзүүлэн самбар, техник хэрэгслээр тоноглогдсон, нөхцөл нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан, өөрийн болон түрээсийн байж болох ба Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага MNS 6541:2015 стандартын шаардлагад нийцсэн байна.

2.1.2. Мөн дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.2.1. Усан замын тээврийн тухай хууль болон дагалдах дүрэм, журмын шаардлагыг харуулсан үзүүлэх самбаруудтай байх;

2.1.2.2. усан замын тэмдэг, тэмдэглэгээний тайлбар бүхий самбарууд;

2.1.2.3. усан замын бүдүүвч зураг;

2.1.2.4. сургалтын техник, хэрэгсэл;

2.1.2.5. усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгүүр, хүч дамжуулах болон сэнс, цахилгаан тоноглол, залуурын механизм, бусад шаардлагатай эд ангиудын ажиллагааны зарчмыг харуулсан макет, үзүүлэнтэй байна.

2.1.3. Онол /хууль, тогтоомж/-ын хичээл заах багш нь магистр, түүнээс дээш зэрэгтэй, тухайн мэргэжлээр ажиллаж байсан дадлага, туршлагатай, мэргэшсэн, усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхтэй, багшлах эрхтэй байна.

2.1.4. Жолоодлогын дадлагын багш нь авто болон усан замын тээврийн хэрэгслийн инженер мэргэжилтэй эсхүл механикийн дунд болон түүнээс дээш боловсролтой, 3-аас доошгүй жил усан замын тээврийн хэрэгсэл жолоодож байсан туршлагатай байхаас гадна сургалтын батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтыг удирдан явуулах чадвартай, хичээл заах аргын дараалал, төлөвлөгөөтэй, усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхтэй байна.

2.2. Жолоодлогын дадлага хийх зориулалтаар ашиглах усан замын тээврийн хэрэгсэл нь тухайн ангилалд тохирсон байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:



- 2.2.1. техникийн хяналтын үзлэгт тэнцсэн байх;
- 2.2.2. “сургалтын тээврийн хэрэгсэл” гэсэн таних тэмдгийг усан замын тээврийн хэрэгслийн их биеийн хажуу талд байрлуулсан байх;
- 2.2.3. жолоодлогын дадлага хийх зориулалтаар ашиглах усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар (нотариатаар гэрчлүүлсэн) байна.

Гурав. Сургалтын зохион байгуулалт

3.1. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын зорилго, агуулга, хөтөлбөр нь суралцагчдад усан замын тээврийн хэрэгслийг жолоодох ур чадварыг эзэмшүүлэх, жолоодох эрх авах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

3.2. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтад хамрагдах хүсэлт гаргасан этгээдийг бүртгэж элсүүлэх асуудлыг сургалтын төв хариуцан зохион байгуулах бөгөөд суралцагчдын ирц, багшийн журнал, холбогдох бүртгэл хөтөлнө.

3.3. Хууль, тогтоомжийн хичээлийн хөтөлбөрийг “Усан замын тээврийн тухай” хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журмын хүрээнд боловсруулна.

3.4. Жолоодлогын дадлагын хичээлээр дараах ур чадварыг эзэмшүүлсэн байна. Үүнд:

3.4.1. салхи, давлагааны хурд, хүч, чиглэлийг тодорхойлох, салхи, давлагаатай үед усан замын тээврийн хэрэгслийг зогсоол, эрэгт байрлуулах, усан замаар тээврийн хэрэгслийг жолоодох, зогсоох, холбогдох тэмдэг, тэмдэглэгээ, дохиог ашиглах, тайлбарлах ур чадвар гэх мэт.

3.5. Аврах ажиллагааны дадлагын хичээлээр дараах ур чадварыг эзэмшүүлсэн байна. Үүнд:

3.5.1. усны мандал дээр хөвж буй “хиймэл хүн” рүү дөхөн очиж, аврах ажиллагааг зөв гүйцэтгэх;

3.5.2. ус руу унасан хүнд аврах цагиргийг шидэж өгөх;

3.5.3. усанд осолдсон хүнд эмнэлгийн анхны шатны тусламж үзүүлэх.

3.6. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний асуудал эрхэлсэн байгууллага болон усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын явцад хяналт тавина.

3.7. Сургалтын төв нь сургалтад хамрагдаж байгаа иргэний мэдээллийг /элсэгчдийн овог нэр, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар бүхий бүртгэлийн жагсаалтыг/ сургалт эхэлснээс хойш ажлын 5 хоногийн дотор Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн нэгдсэн санд бүртгүүлж, баталгаажуулна.

3.8. Жолооч бэлтгэх сургалтыг чанаргүй зохион байгуулсныг эрх бүхий байгууллага тогтоосон нөхцөлд хүний биед болон бусдын усан замын тээврийн хэрэгсэлд суралцагчийн учруулсан гэмтлийн хохирлыг уг сургалтыг зохион байгуулсан хуулийн этгээд хариуцан барагдуулна.

Дөрөв. Мэргэжлийн шалгалт авах үйл ажиллагаа



4.1. Мэргэжлийн шалгалт авах хөндлөнгийн үнэлгээний комиссыг энэ журмын 1.2-т заасан байгууллага болон усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний эрх олгосон хуулийн этгээд хамтран байгуулна.

4.2. Мэргэжлийн шалгалтын хөндлөнгийн үнэлгээний комиссын гишүүн нь усан замын тээврийн хэрэгсэл жолоодох дадлага туршлагатай, "Усан замын тээврийн тухай" болон бусад холбогдох хууль, тогтоомжийн зохих мэдлэгтэй, далайн болон усан замын тээврийн мэргэжилтэй, эсхүл тухайн салбарт 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай хүн байна.

4.3. Мэргэжлийн шалгалтын хөндлөнгийн үнэлгээний комисс нь усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх тухайн сургалтад хамрагдсан суралцагч тус бүрийн сургалтын дүнгийн хүснэгттэй танилцан сургалтад бүрэн хамрагдсан эсэхийг магадалсны дараа мэргэжлийн шалгалт авна.

4.4. Мэргэжлийн шалгалтын тестийг тухайн сургалтын стандартын дагуу мэргэжлийн зөвлөл боловсруулах бөгөөд тестийн асуулт, хариултын нууцлалыг хадгална.

4.5. Мэргэжлийн зөвлөлийг Далайн захиргааны тушаалаар байгуулж, ажиллах журмыг батална.

4.6. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолоочийн мэргэжлийн шалгалтыг онолын болон жолоодлогын дадлага гэсэн хоёр шатлалаар авна. Үүнд:

4.7. Онолын шалгалтад тэнцсэн суралцагчийг жолоодлогын шалгалтад оруулна.

4.8. Жолоодлогын шалгалтыг тухайн шалгалт өгч буй ангиллын тээврийн хэрэгслээр авна. Жолоодлогын шалгалтыг оноогоор дүгнэж, шалгалтын явцад тэмдэглэл хөтөлнө.

Тав. Үнэмлэх олгох

5.1. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолоочийн үнэмлэх олгох арга хэмжээг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний эрх олгосон хуулийн этгээд зохион байгуулна.

5.2. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч болон мэргэшсэн жолоочийн үнэмлэхийг загварын дагуу хэвлүүлэх ба нууцлалын шаардлагыг хангасан байна.


5.3. Үнэмлэхийн загварыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

5.4. Да раах шаардлагыг хангасан усан замын тээврийн хэрэгслийн жолооч нь сургалтад хамрагдаж, мэргэшсэн жолоочийн үнэмлэх авч болно. Үүнд:

5.4.1. Жижиг оврын усан замын тээврийн хэрэгслийг 2-оос дээш жил осол, аюулгүй жолоодож, мэргэжлийн зохих дадал, туршлага хуримтлуулсан байх;

5.4.2. Эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн байх;

5.4.3. Усанд сэлэлтийн дунд түвшний ур чадвар эзэмшсэн болон усчин аврагчийн үнэмлэх, гэрчилгээтэй байх.



5.5. Шинээр болон үнэмлэх нөхөж авах шалгалтад тэнцсэн суралцагч дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- 5.5.1. мэргэжлийн шалгалтын хөндлөнгийн үнэлгээний комиссын дүгнэлт;
- 5.5.2. эрүүл мэндийн үзлэгийн хуудас;
- 5.5.3. жолоочийн үнэмлэх олгох хуудас;
- 5.5.4. 3x4 хэмжээтэй өнгөт гэрэл зураг 3 ш;
- 5.5.5. үнэмлэхийн төлбөр төлсөн баримт;
- 5.5.6. усан замын тээврийн хяналтын улсын байцаагчийн тодорхойлолт (нөхөн авах үед);

5.6. Гал түймэр, үер, усны аюул зэрэг байгалийн хүчин зүйлийн улмаас үнэмлэхээ үрэгдүүлсэн тохиолдолд холбогдох байгууллагын баримт нотолгоог үндэслэн нөхөн олгож болно.

5.5. Энэхүү журмын 5.6-д зааснаас бусад шалтгаанаар мэргэшсэн жолоочийн үнэмлэхээ үрэгдүүлсэн бол энэхүү журмын 4.3-т заасан шалгалтын дүнг үндэслэн нөхөж олгоно.

5.7. Монгол Улсын хууль тогтоомж зөрчсөний улмаас усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан этгээд хөвөлтөд гарах, усан замын тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглоно.


Зургаа. Бусад зүйл

6.1. Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний эрх олгосон хуулийн этгээд нь усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолоочтой холбоотой мэдээллийг солилцох чиглэлээр Цагдаагийн болон төрийн бусад мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтран ажиллана.

6.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---





**Усан замын тээврийн хэрэгслийн жолооч,
мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын
жишиг хөтөлбөр**

1. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөр:

- 1.1. Усан замын тээврийн хэрэгслийн ангилал - 4-өөс дээш хүний суудалтай, 5 метрээс ихгүй урттай жижиг оврын усан замын тээврийн хэрэгслийн жолооч;
- 1.2. Сургалтын төрөл – онолын болон техникийн мэдлэг, жолоодлогын ур чадвар олгох;
- 1.3. Нийт цаг - онол 40 цаг, дадлага 34 цаг;
- 1.4. Жолоодлогын дадлагыг зуны улиралд гол, мөрөн, нуурын усанд гүйцэтгэх ба дадлагын хичээлээр дараах ур чадварыг эзэмшүүлсэн байна. Үүнд:


Ур чадварын түвшин	Эзэмшсэн байх ур чадварын нэр төрөл	Цаг
I	Зогсоол, эрэгт зогсож байгаа усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг асаах, зогсоол, эргээс хөдлөх, хөдөлгөөнд оролцох Зогсоол, эрэгт байрлуулах, бэхлэх Зогсоол, эрэгт зогсох, зогсоол эргээс хөдлөхдөө салхины чиглэл, давлагааны хүч, усны урсгалыг тооцоолох Усан замын тээврийн хэрэгслийг нуур, голын гүехэн хэсэг болон эрэг, зогсоолд хайрдуулахгүй зөв зогсоох, буцаж хөдлөх	12
II	Саадыг тойрон гарах, бага болон өндөр хурдаар эргэлт, бүтэн эргэлт хийх, ухрах үйлдлүүдийг гүйцэтгэх Бусад усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс үүсэх давлагааг хөндлөн гарах Усан замын тээврийн хэрэгслийг хурд авахуулан жолоодох Хөвөлтөд гарсан үед орчны байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, хурдыг тохируулан явах Инерцийг багасган усан замын тээврийн хэрэгслийг огцом зогсоох Усан замын тээврийн хэрэгсэл хоорондын зайг тохируулан явах	8
III	Гэрэлтүүлэг болон урьдчилан анхааруулах дохио, хянах хэрэгслүүд, нэмэлт тоног төхөөрөмжийг ажиллуулах	8

	Усан замын тэмдэг, тэмдэглэгээний заалтыг биелүүлэх	
	Зөрж өнгөрөх, гүйцэж түрүүлэх үйлдлийг гүйцэтгэх	
Аврах ажиллагаа гүйцэтгэх ур чадвар болон бусад чадвар эзэмшүүлэх		
IV	Усны мандал дээр хөвж байгаа “хиймэл хүн” рүү дөхөн очиж, аврах ажиллагааг зөв гүйцэтгэх дадал эзэмших	4
	Усанд унасан хүнд аврах цагиргийг ус руу зөв шидэж өгөх дадлага эзэмших	
	Усанд осолдсон хүнд эмнэлгийн анхны шатны тусламж үзүүлэх чадвар эзэмших	
V	Шөнийн жолоодлогын дадлага хийлгэх	4
VI	Харилцааны ур чадвар эзэмшүүлэх	2
VII	Англи хэлний анхан шатны ярианы мэдлэг олгох	2
НИЙТ ЦАГ		40

1.5. Онолын мэдлэг олгох хичээлийн хөтөлбөр нь техникийн ерөнхий мэдлэг олгох, хөвөлтийн аюулгүй байдлыг хангах талаарх хууль, эрх зүйн мэдлэг олгоход чиглэгдэнэ. (Онолын хичээлийг суралцагч бие даан судалж болно.)

1.6. Суралцагч онолын хичээлээр дараах мэдлэгийг эзэмшсэн байна. Үүнд:

Онолын хичээлийн сэдэв	Сургалтын жишиг хөтөлбөр	Цаг
Усан замын тээврийн тухай хууль тогтоомж	Нийтлэг үндэслэл	2
	Усан замын тээврийн хяналтыг хэрэгжүүлэх төрийн байгууллагын бүрэн эрх	
	Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, усан замын тээврийн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	
	Усан замын тээвэрлэлтэд оролцогчийн эрх үүрэг, хориглох зүйл	
	Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналт, даатгал	
	Хууль, тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага дагалдах дүрэм, журам, стандартууд	
Бусад холбогдох хууль, тогтоомж	Зөрчлийн тухай хууль	2
	Байгаль хамгаалах тухай хууль, тогтоомж	
	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль	
	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	
Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм	Усан замын тээврийн хэрэгслийн ангилал	16
	Усан замын тээврийн хэрэгслийн жолоочийн үүрэг	
	Давуу эрхтэй усан замын тээврийн хэрэгсэл	
	Зам тавьж өгөх /халз тулгаран зөрөх, чиглэл огтлолцох/	
	Гүйцэж түрүүлэх үйлдэл хийх	
	Үзэгдэх орчин хязгаарлагдсан үед усан замын тээврийн хэрэгслийг жолоодох	
	Хөвөлтийн аюулгүй байдлыг хангах дохионы гэрлүүд	
Дуут дохио хэрэглэх		



	Шөнийн жолоодлого	
	Хөвөлтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор туслах тэмдгүүдийг таних, хэрэглэх /усан замын тэмдэг, тэмдэглэгээ/	
	Зангууны ашиглалт, түүний төрөл зориулалт	
	Луужин, газрын зураг ашиглах	
	Аврах хантаазыг сонгох, хэрэглэх, түүний төрөл зориулалт	
	Галын хор, гал унтраах хэрэгслийг ашиглах	
	Ослын үед авах арга хэмжээ, ослын дохио тэмдгүүдийг таних, ашиглах	
	Усны мандал дээрх тусгай зориулалтын /түр/ таних тэмдгүүдийн талаарх ойлголт	
	Усны мотоцикл, бусад хөвөгч хэрэгсэлд тавих тусгай шаардлага	
	Усан замын тээврийн хэрэгслээс байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл, шатах тослох материалын хэрэглээ, хог хаягдлыг зайлуулах	
Техникийн анхны мэдэгдэхүүн	Их биеийн төрөл	8
	Жолоодлогын механизм	
	Хөдөлгүүрийн төрөл	
	Холбоо харилцааны болон цахилгаан тоног төхөөрөмж, гэрэл дохио	
	Бусад төхөөрөмж	
	Далайчдын хэрэглэдэг уяа, зангилааны төрөл, зангидах арга, зориулалт	
Аврах ажиллагаа	Цаг агаарын нөхцөл байдлыг тодорхойлох	8
	Салхи болон давлагааны хүчийг тодорхойлох	
	Далайчдын ёс зүйн талаар	
	Аврах ажиллагааны техник	
	Гол, мөрөн, нуурын (хүйтэн) усанд унасан тохиолдолд осгож амь насаа алдахаас урьдчилан сэргийлэх арга техник	
	Холын аялалд гарахын өмнө анхаарах зүйл	
НИЙТ ЦАГ		36

2. Усан замын тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөр:

2.1. Усан замын тээврийн хэрэгслийн ангилал – 12 хүртэл хүний суудалтай, 5-20 метрийн урттай бага оврын /завь/ усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх жолооч;

2.2. Сургалтын төрөл - тээвэрлэлтийн арга зүй, жолоодлогын ур чадвар олгох;

2.3. Нийт цаг - онол 36 цаг, дадлага 36 цаг;

2.4. Жолоодлогын дадлагыг зуны улиралд гол, мөрөн, нуурын усан дээр хийх ба дадлагын хичээлээр дараах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлсэн байна. Үүнд:

Жолоодлогын дадлагын түвшин	Эзэмшсэн байх ур чадварын нэр	Дадлагын цаг
------------------------------------	--------------------------------------	---------------------


МОНГОЛ УЛААНБААТАР
ЗАМ, ТЭЭВРИЙН ХЭГ ЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн үндэсний бичгийн дэргэний бичиг
2019.08.14/2021

I	Зогсоол, эрэгт зогсож байгаа усан замын тээврийн хэрэгслийг асаах, хөвөлтөд гарах	6
	Зогсоол, эрэгт байрлуулах, бэхлэх,	
	Зогсоол, эрэгт зогсохын өмнө салхины чиглэлийг зөв тооцоолох	
	Усан замын тээврийн хэрэгслийг нуур, голын гүехэн хэсэг болон эрэг, зогсоолд хайрдуулалгүй зөв зогсоох, буцаж хөдлөх	
II	Саадыг тойрон гарах, бага болон өндөр хурдаар эргэлт, бүтэн эргэлт хийх, ухрах үйлдлүүдийг гүйцэтгэх	8
	Бусад усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс үүсэх давлагааг хөндлөн гарах	
	Усан замын тээврийн хэрэгслийг хурд авахуулан жолоодох	
	Хөвөлтөд гарсан үед орчны байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, хурдыг тохируулан явах	
	Инерцийг багасган усан замын тээврийн хэрэгслийг огцом зогсоох	
	Усан замын тээврийн хэрэгсэл хоорондын зайг тохируулан явах	
III	Гэрэлтүүлэг болон урьдчилан анхааруулах дохио, хянах хэрэгслүүд, нэмэлт тоног төхөөрөмжийг ажиллуулах	4
	Усан замын тэмдэг, тэмдэглэгээний заалтыг биелүүлэх	
	Зөрж өнгөрөх, гүйцэж түрүүлэх үйлдлийг зөв гүйцэтгэх	
Аврах ажиллагаа гүйцэтгэх ур чадвар эзэмшүүлэх		
IV	Усны мандал дээр хөвж байгаа “хиймэл хүн”-д дөхөн очиж аврах ажиллагааг зөв гүйцэтгэх	2
	Усанд унасан хүнд аврах цагиргийг ус руу зөв шидэж өгөх	
	Усанд осолдсон хүнд эмнэлгийн анхны шатны тусламж үзүүлэх	
V	Шөнийн жолоодлогын дадлага	6
НИЙТ ЦАГ		36


2.5. Онолын мэдлэгийн хичээлийн хөтөлбөр нь хөвөлтийн аюулгүй байдлыг хангах, тээвэрлэлтийн арга зүй, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдэнэ. (Онолын мэдлэгийн хичээлийг суралцагч бие даан судалж болно)

2.6. Онолын хичээлээр суралцагчдад дараах мэдлэгийг олгосон байна. Үүнд:

Онолын хичээлийн сэдэв	Сургалтын жишиг хөтөлбөр	Цаг
Иргэний хууль, тээвэрлэлтийн гэрээ	Тээвэрлэлтийн гэрээний төрлүүд, түүнтэй холбоотой үүрэг хариуцлага, гэрээ байгуулах, гэрээний нөхцөл шаардлага	1



	Гэнэтийн осол болон учирч болох бусад эрсдэлийн улмаас зорчигч, ачаа тээшинд гэмтэл учирсан эсхүл ачаа, тээш алдагдсан, тээвэрлэлтийн хугацаа хожимдсон зэрэг тохиолдолд авах арга хэмжээ	
	Тээвэрлэлтийн явцад зорчигч, ачаа тээш, гэмтэх, алдагдах, тогтоосон хугацаа хожимдсоноос болж тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх арга зам	
Хөдөлмөрийн болон нийгмийн хамгааллын харилцаа	Ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулах	1
	Ажилтнуудын нийгмийн хамгааллын талаар ажил олгогчийн хүлээх үүрэг, хариуцлага	
Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, төлбөр хураамж, даатгал	Усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгүүлэх, гэрчилгээ, улсын дугаар авахад шаардлагатай баримт бичиг	2
	Усан замын тээврийн салбар дахь даатгалын төрлүүд, үүрэг хариуцлага, баталгаа	
	Усан замын тээвэрлэлттэй холбогдсон төлбөр, хураамж	
Усан замын тээврийн салбарын хууль, дүрэм, журам болон стандартууд	Тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн эрх, үүрэг	6
	Усан замын тээврийн хэрэгслийн техникийн аюулгүй байдалд тавигдах шаардлага, техникийн хяналтын үзлэг	
	Тээвэрлэлтийн ажил, үйлчилгээнд тохирсон усан замын тээврийн хэрэгслийг сонгох	
Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдал	Зорчигч /жуулчин/ тээвэр, тээвэрлэлтийн дүрэм, журамд заасан нөхцөл, шаардлагуудыг	6
	Овор ихтэй ачаа тээвэрлэх	
	Ачаа тээвэрлэх, чиргүүлд ачааг ачих, бэхлэх, буулгах	
	Усан замын тээврийн хэрэгслийн тэнцвэрт байдлыг хангах үүднээс тавцан дээрх ачааг зөв байрлуулж ачих, ачааллыг тэнцүүлэх	
	Аюултай ачааны заалт, таних тэмдгийн мэдлэгтэй байх	
	Усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалт, экологийн аюулгүй байдлыг хангах	
Техникийн мэдлэг, засвар үйлчилгээ хийх	Усан замын тээврийн хэрэгслийн ангилал, их биеийн төрөл, зориулалтыг мэдэж байх	6
	Техникийн засвар үйлчилгээ хийх чадвар эзэмшсэн байх	
	Усан замын тээврийн хэрэгсэл болон түүний нэмэлт тоног төхөөрөмжийн талаар бүрэн ойлголттой байх	
	Хөдөлгүүрийн бүтэц, төрөл, ажиллах зарчмыг мэддэг, техникийн засвар, үйлчилгээ хийж чаддаг байх	
	Тослогоо, хөргөлтийн систем, ажиллах зарчмыг мэдэж байх, засвар, үйлчилгээ хийж чаддаг байх	
Усан замын тээврийн хэрэгслийг хөвөлтөд гаргахад бэлтгэх	Цаг агаарын нөхцөл байдлыг тодорхойлох	2
	Зорчигчдод тохирох аврах хантаазыг сонгох	
	Механизмуудын бүрэн бүтэн байдлыг шалгах, хөдөлгүүрийг асаахад бэлтгэх, хөдөлгөөн эхлэхээс өмнө хөдөлгүүрийг ажиллуулж ажиллагааг нь шалгах	
	Салхи болон давлагааны хүчийг тодорхойлох	4



Аврах ажиллагааг гүйцэтгэх ур чадвар	Далайчдын ёс зүйн талаар ойлголтой байх	
	Аврах ажиллагааны арга техник эзэмших	
	Гол, мөрөн, нуурын (хүйтэн) усанд унасан тохиолдолд осгож амь насаа алдахаас урьдчилан сэргийлэх арга техник эзэмшүүлэх	
	Холын аялалд гарахын өмнө анхаарах зүйлс	
Харилцааны соёл, тээвэрлэлтийн ажил, үйлчилгээний соёл, чанарыг дээшлүүлэх чадвар	Хувь хүний харилцааны соёл, ёс зүй, сэтгэл хөдлөл, биеэ авч явах нийтлэг ёс зүйг төлөвшүүлэх	2
Гадаад хэлний мэдлэг	Үйлчлэгч, үйлчлүүлэгчийн хоорондох харилцааны соёл, үйлчилгээний соёл, чанарыг эзэмшүүлсэн байх	6
	Тээвэрлэлттэй холбогдсон асуудлаар англиар (үйлчилгээний үнэ тариф, чиглэлийн талаар) энгийн зүйл ярих, ойлголцох чадвар эзэмшүүлэх	
НИЙТ ЦАГ		36

---oOo---



Зам, тээврийн хөгжлийн сайд,
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
хамтарсан 2014 оны 14 дугаар сарын 16 -ны
өдрийн 14 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**Усан замын тээврийн хэрэгслийн жолооч,
мэргэшсэн жолоочийн мэргэжлийн
үнэмлэхийн загвар**

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХ
BOAT DRIVER'S LICENSE

Үнэмлэхний дугаар / License number
№ 12345678



Эцэг/эхний нэр / Surname
ГАНБАТ
GANBAT
Нэр / Name
ГАЯПА
GAYARA
Төрөлн өн, сар, өдөр / Date of birth
1996/10/10
Хүйс / Sex
ЭР / MALE
Цусны бүлэг / Blood type
0 (I)

Регистр / Register №
ДК 96101010

Олгосон байгууллага / Issuing authority
Монгол Улсын Далайн захиргаа
Mongolia Maritime Administration

Ангилал Category	Усан замын тээврийн хэрэгслийн жолооч	Усан замын тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч
	5м хүртэл урттай, 4-өөс ихгүй хүний суудалтай	5м-20м хүртэл урттай, 12-оос ихгүй хүний суудалтай
Олгосон хугацаа: Issued:	20.../.../...	20.../.../...
Хүчинтэй хугацаа: Valid until:	20.../.../...	20.../.../...
Мэргэшил Qualification	Усан замын тээврийн хэрэгслийн жолооч	Усан замын тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч

Тайлбар: Үнэмлэхийн дэвсгэр өнгө нь цагаан цэнхэр, түмэн насан хээн суурьтай, зүүн хэсэгт цэцгэн хээний хагас байх

Нуур тал

- Дээд хэсэгт “усан замын тээврийн хэрэгслийн жолоочийн үнэмлэх” гэж Монгол, Англи хэлээр бичнэ;
- Зүүн дээд өнцөгт Монгол Улсын төрийн далбаа;
- Төв хэсэгт “Төрийн соёмбо” шар өнгөөр;
- Хэт ягаан туяаны тусгалд тодрохоор усан хээ болон үнэмлэх олгосон байгууллагын логог олон улсын шаардлагад нийцсэн голограммын нууцлалтайгаар хэвлэх;
- Жолоочийн товч мэдээлэл, 3x4 хэмжээний зурагтай байх;
- Усан замын тээврийн хэрэгслийн ангиллыг тэмдэглэсэн байх;
- Бичвэрийг “Arial” үсгийн фонтоор 6-8 хэмжээтэй бичсэн байна.

Ар тал

- Үнэмлэх олгосон байгууллагын нэр, лого;
- Усан замын тээврийн хэрэгслийн ангиллын тайлбар,
- Үнэмлэх олгосон болон дуусах хугацаа;